



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны
Удирдлагын тогтолцооны журам

Зам, цахилгаан дамжуулах шугамд үзлэг шалгалт хийх журам

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Зам, цахилгаан дамжуулах шугамд үзлэг шалгалт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо : 2013.08.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PRC-0004-М	Хувилбар: 1.0

1 ЗОРИЛГО

Оюу Толгойн барьсан зам, цахилгаан дамжуулах шугам (ЦДШ) болон Оюу Толгойн байнга ашигладаг замд үзлэг шалгалт хийх журмыг тодорхойлох зорилготой. Энэ журамд мөн дээрх газруудаас шувууны үүр, мал, зэрлэг амьтны сэгийг хэрхэн зайлуулах ажлын дарааллыг тусгаж өгсөн болно.

2 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журам нь Оюу Толгойн барьсан бүх зам, эрчим хүчний шугам болон ОТ-н байнга ашигладаг замд хамаарна.

3 АЛБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Албан тушаал	Үүрэг хариуцлага
Биологийн Олон Янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ерөнхий зөвлөх	<ul style="list-style-type: none"> ▪ Биологийн олон янз байдлын хууль, дүрмийн хэрэгжилттэй холбоотой болзошгүй асуудлыг тодорхойлох зорилгоор тайлантай танилцах ▪ Биологийн олон янз байдлын асуудлаар төслийн ажилтнуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх.
Амьтны судалгаа хариуцсан ажилтан	<ul style="list-style-type: none"> ▪ Сар бүр зам, цахилгаан дамжуулах шугамын дагуу үзлэг шалгалт хийх ▪ Үзлэг шалгалтын тайланг сар бүр бэлтгэж, Биологийн олон янз байдал хариуцсан Ерөнхий зөвлөхөд танилцуулах ▪ Шувууны үүрийг танихад Засвар үйлчилгээний багт зөвлөгөө өгөх
Засвар үйлчилгээний хэлтэс	<ul style="list-style-type: none"> ▪ Оюу Толгойн Амьтны судалгаа хариуцсан ажилтнаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр шувууны үүрийг хөдөлгөж болохгүй; ▪ Амьтны судалгаа хариуцсан ажилтны зөвлөгөөний дагуу шувууны үүрийг шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.
Сургалтын хэлтсийн менежер	<ul style="list-style-type: none"> ▪ Зам, цахилгаан дамжуулах шугамын дагуу үзлэг шалгалт хийх, шувууны үүрийг шилжүүлэх тухай тусгай сургалт явуулах
Ажилтнууд, гэрээт байгууллага, зочид	<ul style="list-style-type: none"> ▪ Энэ журмын шаардлагуудыг биелүүлэх ▪ Шаардлагатай бол Зэрлэг амьтдын осол гэмтлийн бүртгэл хөтлөх. ▪ Хамгаалах шаардлагатай төрөл зүйлийн талаар Байгаль орчны хэлтэст мэдэгдэх

4 ЖУРАМ

Зам, цахилгаан дамжуулах шугамд үзлэг шалгалт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо : 2013.08.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PRC-0004-М	Хувилбар: 1.0

4.1 Үзлэг шалгалт хийх

- Амьтны судалгаа хариуцсан ажилтан нь сар бүр дараах чиглэлийн дагуу машинтай явж, зам, цахилгаан дамжуулах шугамын дагуу ажиглалтын аргаар үзлэг шалгалт хийнэ:
 - Оюу Толгойн уурхайн талбайгаас Гашуун Сухайт хүртэлх зам, 220 кВ цахилгаан дамжуулах шугам;
 - Оюу Толгойн уурхайн талбайгаас Гүний Хоолой хүртэлх зам, цахилгаан дамжуулах шугам;
 - Оюу Толгойн уурхайн талбайгаас Ханбогд сум хүртэлх зам, цахилгаан дамжуулах шугам;
- Мал, амьтны сэгийг замаас гаргах, зайлуулах ажлыг Амьтны аймаг хариуцсан ажилтны хяналтан дор явуулах бөгөөд тус ажилтан мал, амьтны зургийг авч, байршлын координатыг тэмдэглэж, мал, амьтныг сэгийг зохих журмын дагуу зайлуулах ажилд хяналт тавина;
- Хэрэв үзлэг шалгалтаар цахилгаан дамжуулах шугам дээр шувууны үүр байгаа нь тогтоогдвол Амьтны судалгаа хариуцсан ажилтан тус үүр нь идлэг шонхорын үүр мөн эсэхийг тодорхойлно. Мөн бол үүрийг хэвээр нь үлдээнэ;
- Хэрэв үүр нь идлэг шонхорынх биш бол Амьтны судалгаа хариуцсан ажилтан Засвар үйлчилгээний хэлтэст хандаж, үүрийг ойролцоох тохиромжтой газарт шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.2 Бүртгэл

- Үзлэг шалгалтаар амьтны ямар нэг төрөл зүйл осолдсон нь тогтоогдвол Амьтны судалгаа хариуцсан ажилтан Зэрлэг амьтдын осол гэмтлийн бүртгэл бөглөнө;
- Үзлэг шалгалтын бус үед осол болсныг ажигласан үндсэн ба гэрээт ажилтнууд Байгаль орчны хэлтэст мэдэгдэх ба тус хэлтэс Зэрлэг амьтдын осол гэмтлийн бүртгэл хөтөлнө;
- Зам дагуу үзлэг шалгалт хийх бүрдээ Амьтны судалгаа хариуцсан ажилтан нь Замын үзлэг шалгалтын маягтын дагуу дэлгэрэнгүй мэдээллийг оруулна;
- Цахилгаан дамжуулах шугамын үзлэг шалгалт хийх бүрдээ Амьтны судалгаа хариуцсан ажилтан нь цахилгаан дамжуулах шугамын үзлэг шалгалтын маягтын дагуу дэлгэрэнгүй мэдээллийг оруулна. Цахилгаан дамжуулах шугамын үзлэг шалгалтын маягтад мөн шувууны үүрийг шилжүүлэн байршуулсан газрын тухай мэдээллийг оруулна;
- Үзлэг шалгалтын үед хамгаалах шаардлагатай төрөл зүйл ажиглагдсан тохиолдолд бүртгэл дээр тусгай тэмдэглэл оруулна;

Оюу Толгойн дэд бүтцийн ойролцоо идлэг шонхорын үүр илэрсэн тохиолдолд үүрний байршлыг бүртгэж, Засвар үйлчилгээний хэлтсийн менежерт мэдэгдсэнээр Засвар үйлчилгээний хэлтсийн ажилтнууд санаандгүй байдлаар үүрийг хөндөхөөс урьдчилан сэргийлнэ.

4.3 Тайлан хянах

- Оюу Толгойн Амьтны судалгаа хариуцсан ажилтан нь Осол гэмтлийн бүртгэл, үзлэг шалгалтын маягыг сар бүр нягтлан шалгаж, дараах мэдээллийг тусгасан

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Зам, цахилгаан дамжуулах шугамд үзлэг шалгалт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо : 2013.08.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PRC-0004-М	Хувилбар: 1.0

тайлан бэлтгэж, Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах Ерөнхий зөвлөхөд өгнө:

- Тусгайлсан хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай төрөл зүйл байгаа эсэх;
- Мал, амьтны үхлийн шалтгаан;
- Хамааралтай бол мал, амьтаны сэг олдсон байршилтай ойролцоох дэд бүтэц (жишээ нь: дунд хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам)
- Байгаль орчны Ахлах ажилтан нь авах арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд хяналт дүгнэлт хийх үүрэгтэй. Уг хяналт дүгнэлтийг жилд нэг удаа хийнэ.
- Хяналт дүгнэлтээр тухайн амьтан хууль бус агнуурын улмаас үхсэн болж таарвал Оюу Толгойн Амьтны судалгаа харицсан ажилтан энэ талаар Сумын ЗДТГ-т мэдэгдэх ба тэд дараагийн арга хэмжээг авна.

5 ЛАВЛАХ МАТЕРИАЛ, ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

Биологийн олон янз байдлын менежементийн төлөвлөгөөнд нэрлэсэнээр

6 БАРИМТ БИЧИЙН ХЯНАЛТ

Бичиг баримтын нэр	ОТ-10-Е9-PRC-0004-М-Зам, цахилгаан дамжуулах үзлэг шалгалт хийх журам_v1.0
Тайлбар	Зам, цахилгаан дамжуулах үзлэг шалгалт хийх журам
Эх зохиогч (д)	Цолмонжавийн Пүрэвсүрэн
Боловсруулсан огноо	2013.08.01
Баталсан	Марк Ньюби, Байгаль орчны менежер
Баталсан огноо	2013,08,10
Хянан өөрчилсөн дугаар	##

Эрсдлийн түвшин	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдлийг үнэлсэн	Хяналт хийх давтамж	Дараагийн хяналт хийх хуваарь
Дунд	2013.08.10	Марк Ньюби	2 жил тутам	2015.08.10

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Засвар өөрчлөлтийн талаарх тэмдэглэл
1.0	2013.08.10	Цолмонжавийн Пүрэвсүрэн	Марк Ньюби, Байгаль орчны менежер	Батлагдсан